

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН КЕМПУУДИЙН ОРЧИНД МӨРДӨХ ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хууль болон “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн кемпийн дотоод үйл ажиллагааг оновчтой зөв зохион байгуулж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, хөдөлмөрийн сахилга бат дэг журмыг бэхжүүлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, кемпийн орчин дах хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, кемпийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү дотоод журмыг кемпийн орчинд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүд болон тэдгээрийн нийт бүрэлдэхүүн дагаж мөрдөнө.

Хоёр. Кемпийн дотоод үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт

- 2.1 Хэсэг бүрийн үйл ажиллагааг тухайн хэсгийг хариуцаж буй Кемп менежер удирдана. Кемпийн өдөр тутмын үйл ажиллагааг кемп менежер хариуцаж, зохион байгуулж ажиллана. Мөн Монгол Улсын хууль тогтоомж болон “Монголын төмөр зам” ТӨХК-ийн удирдлагаас өгсөн шийдвэрт нийцүүлэн дотоод үйл ажиллагаатай холбогдсон асуудалд шийдвэр гарган, санал санаачлагатай ажиллана.
- 2.2 Кемпэд болон кемпийн орчинд гарсан зөрчил, дутагдлыг арилган давтан гаргуулахгүй байх ажлыг зохион байгуулж, нийт ажилтан нарт танилцуулж зааварчлах.
- 2.3 Сахилга ёс зүйн зөрчил, дутагдал гаргасан ажилтны үйлдэлд кемп админ шуурхай хурал хийж, дүгнэлт гаргаж, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн удирдлагад саналаа ирүүлнэ.
- 2.4 Хөдөлмөр хамгааллын осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсдын хөдөлмөрийг оновчтой зохион байгуулж, ажлын байрыг тохижуулах, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.
- 2.5 Нийт бүрэлдэхүүн кемпийн орчинд мөрдөх дотоод журмыг баримталж ажиллана.
- 2.6 Дээд шатны албан тушаалтнаас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж, тухайн албан тушаалтанд заавал илтгэх ба шаардлагатай тохиолдолд бичгээр үйлдэж болно.
- 2.7 Ээлжийн ажилтан амарч байх хугацаанд хаана, ямар утсан дээр байгаагаа заавал тэмдэглүүлж байна.
- 2.8 Ажилтан байгууллагын дотоод журам, тухайн ажил, албан тушаалд заавал дагаж мөрдөх хууль, дүрэм, журам, зааврыг зөрчсөн тохиолдол бүрт “Монголын төмөр зам” ТӨХК-ийн удирдлага болон шууд захирагдах албан тушаалтандаа бичгээр тайлбар гаргана.
- 2.9 Кемпийн ажилчдын ээлж солилцохтой холбоотой харилцааг “Төслийн зохицуулагч”-ийн баталсан “Ээлж солилцох хуваарь”-ийн дагуу зохицуулна.
- 2.10 Хоолны газраар үйчлүүлэхдээ хооллох цагийг нарийн чанд баримтлуулах

2.11 Кемп менежер түлш олгох ба түлшний тайланг

2.12 Кемп менежер усны хэрэгцээг хангах

Гурав. Түр сууцыг ашиглах тухай

3.1 Амрах байрны өдөр тутмын үйл ажиллагаа, зохион байгуулалт болон эд хогшлийн бүрэн бүтэн байдал, орчны аюулгүй байдлыг кемп админ хариуцаж ажиллана. Өдөр тутмын ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг үйлчилгээний ажилтан хариуцаж, хянаж ажиллана.

3.2 Амрах байранд дараах үйлдэл хийхийг хатуу хориглоно. Үүнд :

3.2.1 20:00 цагаас хойш дуу чимээ ихтэй цахилгаан хэрэгсэл ажиллуулах, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулахуйц бусад үйлдэл хийхийг;

3.2.2 Архи, согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх, нийгмийн хэв журам зөрчих, хуулиар хориглосон бусад үйлдэл;

3.2.3 Амрах байрны эд хогшлыг кемп админы зөвшөөрөлгүй гадагш гаргах, гаднаас оруулах, хоорондоо солилцох, гадны хүн зүй бусаар орогнуулах;

3.2.4 Амрах байранд худалдаа үйлчилгээ явуулах, арилжааны зориулалттай эд зүйл, тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис оруулах, хадгалах, амьтан тэжээх ;

3.2.5 Амрах байрны эд хогшлыг зүй бусаар ашиглах, авч гарах, хувьдаа завших;

3.2.6 Амрах байранд хадгалах хугацаа бага, түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн хадгалах, түүгээр хооллох

3.2.7 Компанийн өмч болох амрах байр, гэр болон бусад объектын ханыг дур мэдэн цоолох.

Дөрөв. Эрүүл ахуйг сахих тухай

4.1 Эрүүл ахуйг сахихтай холбоотойгоор кемпийн орчинд байрлаж буй нийт бүрэлдэхүүн дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд :

4.1.1 Амрах байр, гэр, оффис болон бусад хэсэгт байнга цэвэрлэгээ ариутгал хийж, хувийн болон нийтийн ариун цэврийг дээд зэргээр сахина.

4.1.2 Зөвхөн зориулалтын газар бие засах бөгөөд кемпийн орчинд ил задгай бие засахыг хатуу хориглоно. Ариун цэвэрийн өрөө ашигласны дараа гараа угаах.

4.1.3 Ажлаас буух болон хооллох бүрт гар, нүүрийг байнга угааж, ажлын хувцсыг цэвэрлэж, шороо тоосыг арилгасан байна.

4.1.4 Ажилтнууд шүршүүрт орохдоо хувийн ариун цэврийг сахиж, кемпийн “Халуун ус ашиглах журам”-ыг мөрдлөг болгон дагаж мөрдөнө.

4.1.5 Гар нүүрийг зөвхөн зориулалтын газар (ариун цэврийн өрөө)-т угаана.

4.1.6 Хоол бэлтгэх гэрт үйлчилгээний ажилтнуудаас бусад хүн орохыг хориглоно.

4.1.7 Хоол бэлтгэх гэр болон нийтийн хоолны гэрт тамхи татахыг хатуу хориглоно.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах тухай

- 5.1 Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахтай холбоотойгоор кемпийн орчинд байрлаж буй нийт бүрэлдэхүүн дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд :
- 5.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахын шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимтой танилцсан байх, түүнийг чанд мөрдөж ажиллах
 - 5.1.2 Өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд учруулахгүй байх
 - 5.1.3 Ажилд гарахын өмнө тухайн өдөр гүйцэтгэх ажлын талаар хөдөлмөр хамгааллын зааварчилгааг кемпийн удирдлагаас авч зааварчилгааны дэвтэрт гарын үсэг зурсан байх
 - 5.1.4 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн өмсөж, ариг гамтай хэрэглэх
 - 5.1.5 Ажилтан нь өөрийн ажлын байр болон техник хэрэгслийг эзэнгүй орхихгүй байх, гадны хүн оруулахгүй байх үүрэгтэй.
 - 5.1.6 Осол, сүйрэлд нэрвэгсдэд үзүүлэх анхны тусламжийг үзүүлэх арга барил, мэдлэгийг бүрэн эзэмшсэн байна. Мөн өөрийн ажиллаж буй нэгж хэсэг бүрийн “Гамшгийн үеийн ажлын төлөвлөгөө”-г судалж мэдсэн байх шаардлагатай.
- 5.2 Кемпийн орчинд байрлаж буй нийт бүрэлдэхүүнд дараах үйлдлүүдийг хатуу хориглоно. Үүнд:
- 5.2.1 Архи, согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис, эмчийн жоргүй олгогдсон өвчин намдаах, мэдээ алдуулах төрлийн эм, эмэн бүтээгдэхүүн хэрэглэх
 - 5.2.2 Хэрүүл маргаан, зодоон, хулгай, дээрэм, хүч хэрэглэх ёс бус үйлдэл болон эс үйлдэхүй
 - 5.2.3 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хууль болон “Захиргааны хариуцлагын тухай” хуульд заасан зөрчил гаргах
 - 5.2.4 Зориулалтын бус, зөвшөөрөгдөөгүй цэгт тамхи татах
 - 5.2.5 Ажлын цагийн хуваарийг зөрчих
 - 5.2.6 Амарч байгаа ажилчид зөвшөөрөлгүй дур мэдэн кемпийн орчноос гарах
 - 5.2.7 Кемпэд хамаарал бүхий тээврийн хэрэгсэл 22:00 цагаас хойш кемпийн орчноос гадагш зам тээврийн хөдөлгөөнд оролцох
 - 5.2.8 Үзэгдэх орчин хязгаарлагдсан тоостой болон шороон шуургатай буюу байгалийн аюулт үзэгдэл болж буй нөхцөлд тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцох
 - 5.2.9 Ажилтнууд нь зөвхөн өөрсдийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан буюу тухайн ажил хариуцсан удирдах ажилтнаас өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх ба өөр ажил хийх
 - 5.2.10 Кемпед зөвшөөрөлгүйгээр гадны хүн оруулах, гаргах
- 5.3 Ажлын явцад удирдлагаас заагдсан үүрэгт ажилд өөрчлөлт хийх шаардлага гарвал заавал анх шийдвэр өгсөн ажилтнаар дамжуулан гүйцэтгэнэ.

Зургаа. Галын аюулгүй байдлыг хангах тухай

- 6.1 Галын аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор кемпийн орчинд байрлаж буй нийт бүрэлдэхүүнд дараах үйл ажиллагаа, үйлдлийг хориглоно. Үүнд :
- 6.1.1 Амрах байр, гэр болон бусад объектын хаалга, гарц хааж таглах, эд зүйл хураах
 - 6.1.2 Хялбар авалцан асах, тэсэрч дэлбэрэх бодис, хий, шингэнийг зөвшөөрөлгүй өрөө тасалгаанд хадгалах
 - 6.1.3 Цахилгаан тоног төхөөрөмжийг хүчдэлээс салгалгүй засвар үйлчилгээ хийх
 - 6.1.4 Галын аюултай орчинд гагнүүр хийх, ил гал гаргах, тамхи татах
 - 6.1.5 Гал унтраах багаж хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах
 - 6.1.6 Сууц, гэр болон оффист гар утас, цахилгаан хэрэгслийг цэнэглэхдээ харгалзах хүнгүй орхих
 - 6.1.7 Кемп админы зөвшөөрөлгүйгээр мэргэжлийн бус хүн кемпийн генераторт дур мэдэн засвар үйлчилгээ хийх
 - 6.1.8 Кемп админы зөвшөөрөлгүйгээр мэргэжлийн бус хүн кемпийн эрчим хүчний самбарт дур мэдэн засвар үйлчилгээ хийх, кемпийн тогыг хэсэгчилж болон нийтээр нь салгах, залгах
- 6.2. Цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ажил эхлэх болон тарах үед асаах болон унтраах үйлдэл хийхийн өмнө бүрэн бүтэн байдлыг шалгаж ажиллана.
- 6.2.1 Ажлын цаг дуусах үед хэрэглэсэн цахилгаан хэрэгслээ бүрэн гүйцэд салгасан эсэхээ заавал нягталж шалгана.

Долоо. Байгаль орчныг хамгаалах тухай

- 7.1 Байгаль орчныг хамгаалахтай холбоотойгоор кемпийн орчинд байрлаж буй нийт бүрэлдэхүүн дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд :
- 7.1.1 Байгаль орчныг хамгаалах талаар хүн бүр санаачлага гаргаж, байгальд ээлтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.
 - 7.1.2 Автомашин болон техник хэрэгслүүд газрын хөрсийг зориулалтын бусаар эвдэх, замгүй газраар явах, шинэ зам гаргахыг хориглоно.
 - 7.1.3 Автомашин болон техник хэрэгслийн засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын газар буюу хэсэгт хийж гүйцэтгэнэ.
 - 7.1.4 Жолооч, засварчин бүр хөрсөн дээр тухайн техникийн тос, тосол гоожихоос сэргийлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.
 - 7.1.5 Бүх төрлийн хог хаягдал болон тамхины ишийг зөвхөн зориулалтын газарт хаяна.
 - 7.1.6 Бүх төрлийн хог хаягдал болон тамхины ишийг ил задгай хаяхыг хатуу хориглох ба гаргасан зөрчлийг “Хог хаягдлын тухай” хууль болон “Тамхины хяналтын тухай” хуульд нийцүүлэн арга хэмжээ авна.
- 7.2 Кемпийн орчин дахь гадна их цэвэрлэгээг 7 хоногт 1-ээс доошгүй удаа нийт бүрэлдэхүүнийг хамруулж хийнэ.
- 7.2.1 Кемпийн орчинд байрлаж буй нийт бүрэлдэхүүн товлосон цагт бэлэн байж их цэвэрлэгээнд оролцох үүрэгтэй.

Найм. Техник ашиглах тухай

8.1 Техник ашиглалттай холбоотойгоор кемпийн орчинд байрлаж буй нийт бүрэлдэхүүн дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд :

8.1.1 Машин, механизм, тоног төхөөрөмжийг зөвхөн тухайн техникийг хариуцсан хүн ашиглана.

8.1.2 Машин техникийг хариуцсан жолооч, удирдах ажилтны зөвшөөрөлгүйгээр дур мэдэн хөдөлгөх, кемпийн орчноос гарах хөдөлгөөн хийх

8.1.3 Автомашины жолооч орчны байдлыг биеэр шалгаж, дуут дохио өгч хөдөлгөөнийг эхлүүлнэ.

8.1.4 Тээврийн хэрэгслийн жолоочийн биеийн байдал муудах, жолоо барих чадвараа алдах болон бусад онцгой тохиолдлоос бусад үед дур мэдэн жолоо шилжүүлэхийг хатуу хориглоно.

8.1.5 Кемпийн нутаг дэвсгэрт 50 метр дотор бүх төрлийн тээврийн хэрэгслүүд 5км/цагаас ихгүй хурдтай хөдөлгөөн үйлдэнэ.

Ес. Бусад

9.1 Энэ журмын биелэлттэй холбоотой болон шаардлагатай бусад асуудлаар кемп админы тавьсан албан ёсны шаардлагыг кемпийн орчинд байрлаж буй нийт бүрэлдэхүүн дагаж биелүүлэх үүрэгтэй.

9.2 Энэ журмыг зөрчсөн ажилтанд “Монгол Улс”-ын холбогдох хууль тогтоомж болон “Байгууллага хоорондын гэрээ” мөн “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.3 Энэ журмыг зөрчсөнөөс үүдэн компанийн эд хөрөнгөд учирсан хохирлыг бүрэн барагдуулах хариуцлага хүлээлгэнэ.

9.4 Кемпийн өдөр тутмын үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, тус нөхцөл байдлыг шуурхай арилгах арга хэмжээ авна.

9.4.1 Дээрх нөхцөл байдал үүсэх болсон шалтгааныг яаралтай олж тогтоон, давтан гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлж ажиллана. Шаардлагатай тохиолдолд удирдах албан тушаалтанд мэдэгдэж, зохих зааврын дагуу ажиллана.